МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

# ТӨСВИЙН ТОДОТГОЛ 2025

2025 он

# 2025 ОНЫ ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ ӨМНӨХ ТӨСӨӨЛЛӨӨС ЭРС МУУДЛАА




## 2024.10 САРД

- ✓ ИНФЛЯЦ **ТОГТВОРЖИНО**;
- ✓ МӨНГӨНИЙ БОДЛОГО **СУЛАРНА**;
- ✓ ТӨСВИЙН БОДЛОГЫН **ОРОН ЗАЙ НЭМЭГДЭНЭ**;
- ✓ ЭДИЙН ЗАСАГ ТОГТВОРЖИЖ, **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ӨСНӨ ГЭЖ ТӨСӨӨЛЖ БАЙСАН**

## 2025.04 САРД

- **ХУДАЛДААНЫ ДАЙН** ХУРЦАДСАН
- **ТОДОРХОЙГҮЙ БАЙДАЛ** ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА
- **НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ** ДОГОЛДСОН
- ЭРЭЛТ СУЛАРЧ, **ӨСӨЛТ СААРСАН**

# ГАДААД ХУДАЛДАА /5 САРЫН БАЙДЛААР/

## ГАДААД ХУДАЛДАА 885 САЯ АМ.ДОЛЛАРЫН АШИГТАЙ БАЙНА.




## ГАДААД ВАЛЮТЫН УЛСЫН НӨӨЦ 5.2 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР БАЙНА.




## ГОЛЛОХ УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭ ӨСӨЖ БАЙНА.

**ЗЭСИЙН БАЯЖМАЛ,** мянган.тонн




**АЛТ,** тонн




**ТӨМРИЙН ХҮДЭР,** мянган.тонн




## ЗЭСИЙН БАЯЖМАЛ, АЛТНЫ ҮНЭ ӨСӨЖ БАЙНА.

**ЗЭСИЙН БАЯЖМАЛ,** доллар/тонн




**АЛТ,** доллар/унц




*эхний 5 сарын дунджаар*

**ТӨМРИЙН ХҮДЭР,** доллар/тонн



# НҮҮРСНИЙ ЭКСПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭ

**ХЯМД НҮҮРСНИЙ ЭКСПОРТОД ЭЗЛЭХ ХУВЬ ӨССӨН НЬ ЭКСПОРТЫН ОРЛОГЫН БУУРАЛТАД ГОЛЛОН НӨЛӨӨЛЛӨӨ.**

**2024.06.12**




**БИЕТ ХЭМЖЭЭ**

**35.1** САЯ ТОНН

Үнээс уул уурхайн биржээр:

**13.8** САЯ ТОНН

**ЭКСПОРТЫН ОРЛОГО**

**4.1** ТБ.$

**2025.06.12**




**34.2** САЯ ТОНН

Үнээс уул уурхайн биржээр:

**2.1** САЯ ТОНН

**-1.7** ТБ.$

**2.4** ТБ.$

## 2025 ОНЫ ХБГ-ЭЭР

**БИЕТ ХЭМЖЭЭ**

**83.0** САЯ ТОНН

**ЭКСПОРТЫН ОРЛОГО**

**6.2** ТБ.$

**ЭКСПОРТЫН ОРЛОГО БУУРАХ ДҮН**

**ӨМНӨХ ОНООС** **-2.5** ТБ.$

**ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС** **-2.4** ТБ.$

**УГ ДҮНГЭЭР ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГВУН БУУРАХ ЭРСДЭЛТЭЙ**

ТӨСВИЙН ТОДОТГОЛ-2025

# НҮҮРСНИЙ ҮНИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

**КОКСЖИХ НҮҮРСНИЙ ҮНЭ** | 2025.06.12-ны байдлаар: **705** юань | Өмнөх сараас: **-12%** | Өмнөх оны мөн үеэс: **-38%**

**ГАНЦМОД БООМТЫН ТҮҮХИЙ КОКСЖИХ НҮҮРСНИЙ ҮНЭ,** *улирал, юань*

- 2024 оны сүүлчээр коксжих нүүрсний үнэ **1,089 юаньд хүрч, олон жилийн дундаж түвшинд** ойртсон.




- 2025 оны эхэнд **900 юаньд хүрч, дундаж түвшнээс доогуур** орсон байна. Улмаар тавдугаар сарын дунд үе хүртэл үнэ хэлбэлзэлтэйгээр алгуур буурч, **825 юаньд** хүрсэн.

- Харин 5 дугаар сарын сүүлчээс 6 дугаар сарын эхэн хүртэл коксжих нүүрсний үнэ огцом буурч, ойролцоогоор **120 юаниар унасан**.



# БНХАУ-ЫН НҮҮРС, ГАНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛ

**ЗАХ ЗЭЭЛД НИЙЛҮҮЛЭЛТИЙН ИЛҮҮДЭЛ НЭМЭГДЭЖ, НҮҮРСНИЙ НӨӨЦ ӨССӨН НЬ НҮҮРСНИЙ ҮНИЙГ БУУРУУЛАХ ГОЛ ШАЛТГААН БОЛЖ БАЙНА.**

Хятадын нийт **коксжих нүүрсний нөөц** 2025 оны 4 дүгээр сард **23.5 сая** тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 32 хувиар өссөн.




**БНХАУ-ЫН КОКСЖИХ НҮҮРСНИЙ ИМПОРТ 2025 ОНД НИЙТ 105 САЯ ТОНН БОЛЖ ӨМНӨХ ОНООС 16 САЯ ТОННООР БУЮУ 13 ХУВИАР БУУРАХ ХҮЛЭЭЛТТЭЙ БАЙНА.**

*Sxcoal-ийн тооцоолол*




## ГАНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

**ГАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ БУУРУУЛАХ БОДЛОГО БАРИМТАЛЖ БАЙГАА Ч, 2025 ОНД БУУРАХГҮЙ БАЙХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА.**




**Төсөөлөлд ашигласан нөхцөл:**

- Зарим төрийн өмчит компаниуд 3-4 хувиар бууруулна гэсэн төлөвлөгөө гаргасан.

**Үйлдвэрлэл буурахгүй байх боломжтой.**

- Үйлдвэрлэл оны эхнээс 345 сая.тонн болж, **1.2 хувиар нэмэгдсэн,**
- Гангийн **экспорт нэмэгдсэн,** улирлын нөлөөгөөр холбогдуулан **барилгын эрэлт нэмэгдсэн**.

**ГАНГИЙН ЭКСПОРТ 2025 ОНД ҮРГЭЛЖЛЭН ӨСӨХӨӨР БАЙНА.**




Эхний 5 сард **48.5** сая.тонн ган экспортолж өмнөх оны мөн үеэс **8.9** хувиар нэмэгдсэн.

**Гангийн экспорт, улсуудаар эзлэх %**

- Өмнөд Солонгос – 12%;
- Вьетнам – 10%;
- Арабын нэгдсэн Эмират – 8%;
- Тайланд – 6%;
- Филиппин – 5%;
- Европын Холбоо – 3%

# НЭГДСЭН ТӨСВИЙН 4,5 ДУГААР САРЫН ГҮЙЦЭТГЭЛ

/ТЭРБУМ ТӨГРӨГ/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024 У-ГҮЙЦ | 2025 БАТ | 2025 4 САР | 2025 5 САР |
|---|---|---|---|---|
| **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **29,670.8** | **33,469.9** | **8,487.8** | **10,711.6** |
| *ТАТВАРЫН ОРЛОГО* | 27,417.4 | 31,557.2 | 7,954.1 | 10,035.4 |
| *ТАТВАРЫН БУС* | 2,253.5 | 1,912.7 | 533.7 | 676.2 |
| **НИЙТ ЗАРЛАГА** | **30,591.1** | **33,431.5** | **8,545.7** | **10,971.5** |
| *ЦАЛИН, ХӨЛС* | 5,368.5 | 6,527.8 | 2,035.0 | 2,631.1 |
| *ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР* | 1,236.0 | 1,297.1 | 488.9 | 517.5 |
| *ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ* | 7,970.8 | 6,451.5 | 708.8 | 1,046.1 |
| *ТАТААС БА УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ* | 11,383.8 | 12,932.6 | 4,249.3 | 5,325.9 |
| *ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ* | 2,506.4 | 1,959.4 | 187.6 | 251.8 |
| *БУСАД ЗАРДАЛ* | 2,125.6 | 4,263.1 | 876.1 | 1,199.1 |
| **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ** | **-920.2** | **38.3** | **-57.9** | **-259.9** |

ТӨСВИЙН ТОДОТГОЛ-2025

# ТӨСВИЙН ОРЛОГЫН 5 ДУГААР САРЫН ГҮЙЦЭТГЭЛ

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.05 ГҮЙЦ | 2025 БАТ | 2025.05 ГҮЙЦ | ЗӨРҮҮ 2025-2024 |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ОРЛОГО** | **12,729.7** | **36,435.6** | **11,381.6** | **-1,348.1*** |
| **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО** | **12,072.0** | **33,469.9** | **10,711.6** | **-1,360.4** |
| ААНОАТ | 2,833.9 | 7,212.2 | 2,174.2 | -659.7 |
| ДОТООДЫН НӨАТ | 993.8 | 3,317.0 | 1,053.8 | 60.0 |
| ХХОАТ | 977.6 | 2,800.0 | 1,184.1 | 206.5 |
| НДШ, ЭМДШ | 1,728.0 | 6,005.3 | 2,076.6 | 348.6 |
| АМНАТ | 1,859.2 | 3,338.3 | 612.9 | -1,246.3 |

Тэнцвэржүүлсэн орлого 2025 оны 5 дугаар сарын гүйцэтгэлээр 10,711.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **1.4 их наяд төгрөгөөр буюу 11.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна**.

**2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 1 удаагийн шинж чанартай 775.5 тэрбум төгрөгийн орлого орсон. Энэхүү нэмэлт орлогыг хасаж тооцвол өмнөх оны мөн үеэс орлого* ***526.2*** *тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй гарсан.*

*тэрбум төгрөг*

Сүүлийн жилүүдэд дунджаар эхний *5 сард нийт орлогын **36.6 орчим хувь нь төвлөрдөг бол энэ жил 31.2 хувийн** гүйцэтгэлтэй гарсан байна.

**Өмнөх жилүүдийн дундаж (2024 оныг оруулахгүйгээр).*



# АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

## АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ГҮЙЦЭТГЭЛ

/тэрбум төгрөг/




ААНОАТ-ын орлого 2025 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр 2,324.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22 хувиар буурсан байна. Энэхүү бууралтад **уул уурхайн салбар, тэр дундаа нүүрсний үнэ мөн оны мөн үеэс буурсан нь голлон нөлөөлсөн байна**. Мөн 2025 оны I улиралд эдийн засгийн өсөлт 2.4 хувьтай гарсан нь өмнөх оны мөн үеэс 5.5 пунктээр буурч, өсөлт удааширсан нь ААНОАТ-ын орлогын бууралтад нөлөөллөө.

## ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ




2025 оны эхний улиралд эдийн засгийн өсөлт 2.4 хувьтай гарч**, үүнээс уул уурхайн салбар 0.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.**

## ААНОАТ-Т УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ ХУВЬ




ААНОАТ-ын орлогод уул уурхайн салбарын эзлэх хувийн бууралтад **нүүрсний салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн эзлэх хувь 33 хувьд хүрч өмнөх оноос 24 нэгжээр** буурсан нь голлон нөлөөлсөн байна.

ТӨСВИЙН ТОДОТГОЛ-2025

# АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

| ҮЗҮҮЛЭЛТ | 2024.05 ГҮЙЦ | 2025 БАТ | 2025.05 ГҮЙЦ | ЗӨРҮҮ |
|---|---|---|---|---|
| **НИЙТ АМНАТ** | **2,451.3** | **5,644.2** | **1,096.1** | **-1,355.2** |
| НҮҮРС | 1,732.1 | 3,208.5 | 313.2 | -1,418.9 |
| ЗЭС | 483.1 | 1,737.8 | 592.9 | +109.8 |
| ТӨМӨР | 29.6 | 226.5 | 49.7 | +20.1 |
| АЛТ | 82.5 | 181.3 | 55.7 | -26.8 |













Энэ оны эхний 5 дугаар сарын байдлаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 1,098.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 55.2 хувиар буюу 1,352.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зэсийн баяжмал болон төмрийн хүдэр, баяжмалын экспорт өсөж байгаа нь АМНАТ-ын орлогод эерэг нөлөө үзүүлж байгаа ч нүүрсний дундаж үнэ энэ оны эхний 5 дугаар сарын байдлаар тонн тутамд 71.9 ам.доллар болж өмнөх оны мөн үеэс **39 хувиар буюу 46.6 ам.доллароор буурсан нь АМНАТ-ын орлого буурахад голлон нөлөөлөөд байна.**

# ЗАСГИЙН ГАЗРЫН СОРИЛТ

- **Макро тогтвортой байдлыг хадгалах**
  - Бодлогын уялдаа: Мөнгөний хатуу бодлого + Төсвийн хумих бодлого
  - Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх
  - Экспорт, гадаад валютын нөөц нэмэгдүүлэх
- **Төрийн оролцоог оновчтой, үр ашигтай болгох**
  - ТӨҮГ-ын бүтцийн өөрчлөлт: Хувийн хэвшлийн орон зай
  - Бизнесийн орчныг сайжруулах: Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт
  - Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх: Үндэсний өрсөлдөх чадвар
- **Төрийн албыг цомхон, чадварлаг болгох**
  - Зарим чиг үүргийг хувийн хэвшилд хариуцуулах,
  - Төрийн цахим шилжилтийг эрчимжүүлэх
  - Ажил, үүргийн давхцлыг арилгах

# ТӨСВИЙН ТОДОТГОЛД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- Төрийн албаны чиг үүргийн давхардлыг арилгаж, данхар бүтцийг хумина.
- Удирдах, гүйцэтгэх ажилтны тоог оновчтой тогтоох замаар даргын тоо бууруулна.
- Бүх шатны төсвийн байгууллагуудын тэвчиж болох зардлыг бүрэн хэмнэнэ.
- Салбаруудад хэрэгжиж байгаа хөтөлбөр, арга хэмжээний зардлыг он дуустал хэмнэж, харин хэрэгжиж эхлээгүй байгаа хөтөлбөр, арга хэмжээг бүрэн хэмнэнэ.
- Нийслэл Улаанбаатар хотод бондоор хэрэгжүүлэх төслийн зардлыг хүлээгдэж байгаа гүйцэтгэлтэй уялдуулан 10 хувиар хэмнэнэ.

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА!